

**Erdbeere**

Герман нэршил

**Гүзээлзгэнэ**Монгол нэршил  
Монголд 2 зүйл***Fragaria orientalis***

Латин нэршил

**Тодорхойлолт:**

Ойн гүзээлзгэнэ нь жимсгэний төрлийн, олон настай өвслөг ургамал юм. 5-25 см хүртэл өндөр ургах бөгөөд ойн зах, цоорхойгоор зонхилон тархсан байдаг. Шувууд, мэрэгчид, үнэг, хэрэм, цох, жаран хөлт, шоргоолж зэрэг шавжнууд хүртэл гүзээлзгэний жимсгэнээр хооллодог. Амтлаг жимсгэнийг шууд дангаар нь идэхээс гадна чанамал, ундаа хийж хэрэглэж болно.

**Мэдээлэл:** Цэцэрлэгт тусад нь талбай гаргаж тариална. Жимсийг нь хуурай байлгахын тулд өвсөөр хүрээлүүлэх хэрэгтэй. Шинэ суулгацуудыг зуны сүүлчээр тарихад тохиромжтой.

**Грайфсвалдын Их Сургуулийн гербари** [http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora\\_search=Taxon&action=species&gen=Fragaria](http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora_search=Taxon&action=species&gen=Fragaria)

Дэлгэрэнгүй мэдээлэл, тархалтын зураг болон бусад зургуудтай дээрх холбоосоор орж танилцана уу.